

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2011 оны 2 дугаар сар

1. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ:

2011 оны 2 дугаар сарын байдлаар даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон тусгай зөвшөөрөлд орсон өөрчлөлтүүд дараах байдалтай байна:

| /тоогоор/ | | | | | |
|-----------|--|--------|----------------|-----------|---------|
| № | Тусгай зөвшөөрөл эзэмшигчид, өөрчлөлт | 2011-I | Нэмэгдсэн | Хасагдсан | 2011-II |
| 1 | Даатгалын компани | 17 | | | 17 |
| 2 | Даатгалын компанийн салбар | 139 | | | 139 |
| 3 | Даатгалын төлөөлөгч | 1662 | | | 1662 |
| 4 | Даатгалын зуучлагч | 9 | | | 9 |
| 5 | Даатгалын хохирол үнэлэгч | 7 | | | 7 |
| 6 | Актуарч | 12 | | | 12 |
| 7 | Бусад | | 2 ¹ | | |

Тайлант үед даатгалын компани, тэдгээрийн салбар, даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч, актуарчийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

¹Хорооны даргын 2011 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 23 дугаар тушаалаар “Соёмбо даатгал” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн бүтцэд өөрчлөлт оруулахыг;

¹Хорооны даргын 2011 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 25 дугаар тушаалаар “Ард даатгал” ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүн, дүрмийн сангийн бүтцэд өөрчлөлт оруулахыг тус тус зөвшөөрсөн.

2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын байгууллагуудын 2011 оны 2 дугаар сарын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2010 оны 2 дугаар сарынхтай харьцуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :


| /төгрөгөөр/ | | | |
|-------------|--|-----------------|-----------------|
| № | Үзүүлэлт | 2010-II | 2011-II |
| 1 | Даатгалын нийт хураамж | 1,399,842,720.5 | 2,307,587,852.0 |
| 2 | Олгосон нийт нөхөн төлбөр | 345,313,222.1 | 566,584,125.2 |
| 3 | Давхар даатгалд төлсөн хураамж | 150,552,151.0 | 510,219,368.4 |
| 4 | Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/ | 3,872 | 4,947 |

| | | | |
|---|---|------------------|------------------|
| 5 | Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн | 49,097,880,000.0 | 22,739,296,272.2 |
| 6 | Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн | 37,145,000.0 | 43,264,118.0 |

2011 оны 2 дугаар сард даатгалын компаниудын төвлөрүүлсэн даатгалын нийт хураамжийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 907.7 сая төгрөгөөр өсч, урд сарынхаас 185.4 сая төгрөгөөр буурсан, олгосон даатгалын нөхөн төлбөр өмнөх оны мөн үеийнхээс 221.3 сая төгрөгөөр өсч, урд сарынхаас 44.9 сая төгрөгөөр буурсан, давхар даатгалд төлсөн хураамж өмнөх оны мөн үеийнхээс 359.7 сая төгрөгөөр, урд сарынхаас 210.3 сая төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Тайлант үед шилжүүлсэн давхар даатгалын хураамжийн 35.0 хувь буюу 178.3 сая төгрөгийг “Моннис даатгал” ХХК, 30.5 хувь буюу 155.9 сая төгрөгийг “Миг даатгал” ХХК, 20.5 хувь буюу 104.6 сая төгрөгийг “Монгол даатгал” ХХК, 8.9 хувь буюу 45.3 сая төгрөгийг “Тэнгэр даатгал” ХХК, 4.9 хувь буюу 25.3 сая төгрөгийг “Бодь даатгал” ХХК, 0.2 хувь буюу 0.9 сая төгрөгийг “Ард даатгал” ХХК тус тус шилжүүлсэн байна.

Даатгалын компаниудын даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөр, давхар даатгалд төлсөн хураамж, сая төгрөгөөр



Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

| № | Үзүүлэлт | /төгрөгөөр/ | |
|---|---------------------------------------|--------------|--------------|
| | | 2010-II | 2011-II |
| 1 | Даатгалын нийт хураамж | 40,929,451.0 | 18,108,187.6 |
| 2 | Олгосон нийт нөхөн төлбөр | 1,935,917.3 | 4,740,740.0 |
| 3 | Давхар даатгалд төлсөн хураамж | | |
| 4 | Байгуулсан даатгалын гэрээний тоо | 9 | 8 |
| | Үүнээс: -Хувь хүний хугацаат даатгалд | 4 | 2 |
| | -Байгууллагын хугацаат даатгалд | 5 | 2 |

| | | | |
|---|---|--------------|--------------|
| | -Өндөр хамгаалалттай ЭМД-д | | |
| | -Эмнэлгийн мөнгөний даатгалд | | |
| | -Сургалтын төлбөрийн хуримтлалын даатгалд | | 1 |
| | -Тэтгэврийн даатгалд | | |
| | -Орон сууцны даатгалд | | 1 |
| | -Хуримтлалын даатгалд | | 2 |
| | -Зээлдэгчийн амь насны даатгалд | | |
| 5 | Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн | 20,000,000.0 | 20,000,000.0 |
| 6 | Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн | 400,000.0 | 320,000.0 |

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн 2011 оны 2 дугаар сарын даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг 2010 оны мөн үеийнхтэй харьцуулбал даатгалын хураамжийн орлого 22.8 сая төгрөгөөр буурч, даатгалын нөхөн төлбөр 2.8 сая төгрөгөөр өссөн, өмнөх сарынхтай харьцуулахад даатгалын хураамжийн хэмжээ 9.7 сая төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөр 0.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Даатгалын зуучлагч компаниудын хувьд :

| № | Үзүүлэлт | /төгрөгөөр/ | | |
|---|---|-----------------|------------------|-----------------|
| | | 2010-ХII | 2011-I | 2011-II |
| 1 | Даатгуулагчаас шууд орж ирсэн даатгалын хураамж | 29,395,964.7 | 17,536,876.2 | 12,278,487.7 |
| 2 | Даатгалын зуучлагчийн орлого | 17,037,806.3 | 13,180,745.4 | 12,488,198.0 |
| 3 | Зуучилсан даатгалын гэрээний тоо | 34 | 32 | 35 |
| 4 | Зуучилсан даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн | 3,807,505,112.4 | 16,230,000,000.0 | 2,500,000,000.0 |

2011 оны 2 дугаар сарын байдлаар даатгалын зуучлагч компаниуд 35 даатгалын гэрээг даатгагчдад зуучлан 12.3 сая төгрөгийн зуучлалын орлого олсон байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниудын хувьд :

| № | Үзүүлэлт | /төгрөгөөр/ | |
|---|--|--------------|--------------|
| | | 2011-I | 2011-II |
| 1 | Даатгалын хохирол үнэлсэний орлого | 4,252,185.2 | 2,300,414.6 |
| 2 | Үнэлсэн даатгалын хохирлын тоо | 304 | 230 |
| 3 | Үнэлсэн даатгалын хохирлоос хамгийн өндөр хохирлын дүн | 28,870,000.0 | 24,074,000.0 |

2011 оны 2 дугаар сарын байдлаар даатгалын хохирол үнэлэгч компаниуд 230 даатгалын хохирлыг үнэлж, 2.3 сая төгрөгийн даатгалын хохирол үнэлсний орлоготой ажиллажээ.